ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/06/НА/СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2022 он


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 3
3. Аудитын тайлан ........ 10
  3.1 Ерөнхий зүйл ........ 10
  3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 10
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
  3.4 Материаллаг байдал ........ 11
  3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 11
  3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11
  3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 12
  3.8 Аудитын гол асуудал ........ 12
  3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 12
  3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 13
  3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 13
4. Аудитын илрүүлэлт ........ 13

2117144066
ХТҮ4037...8030891

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГ | Засгийн газар |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

2117144066
ХТҮ4037 9030891

## 1.Аудитын санал дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000 Дорнод аймаг, Хэрлэн сум 2-р баг
ЗДТГ-ын II байр. Утас/Факс: 7058-4203

2022.02.21 № 79

танай ________ -ны № ________ -т

ГУРВАНЗАГАЛ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.АЗЗАЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

011020841

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,329,000.00** | **3,399,432.00** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 3,329,000.00 | 3,399,432.00 |
| 351 | **Түүхий эд материал** | 185,000.00 | 185,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 185,000.00 | 185,000.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 3,144,000.00 | 3,214,432.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 258,000.00 | 328,432.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,886,000.00 | 2,886,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,555,532.18** | **6,307,894.41** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 8,555,532.18 | 6,307,894.41 |
| 392 | **Биет хөрөнгө** | 8,555,532.18 | 6,307,894.41 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 11,948,230.00 | 11,948,230.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (5,539,639.09) | (7,245,485.17) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 6,507,000.00 | 6,507,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,360,058.73) | (4,901,850.42) |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **11,884,532.18** | **9,707,326.41** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,884,532.18** | **9,707,326.41** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 11,884,532.18 | 9,707,326.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,327,000.00 | 1,327,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,327,000.00 | 1,327,000.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 10,557,532.18 | 8,380,326.41 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 10,557,532.18 | 10,557,532.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (2,177,205.77) |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** VI=IV+V | **11,884,532.18** | **9,707,326.41** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **265,432,700.00** | **101,611,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,000,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,000,000.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,000,000.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 8,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **257,432,700.00** | **101,611,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 201,000,000.00 | 41,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,000,000.00 | 41,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,432,700.00 | 60,611,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,432,700.00 | 60,611,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **261,727,416.95** | **103,788,805.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **261,727,416.95** | **103,788,805.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 256,833,139.24 | 98,959,873.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 41,930,192.29 | 44,234,741.81 |
| 210101 | Үндсэн цалин | 36,183,192.29 | 38,525,312.81 |
| 210104 | Урамшуулал | 5,747,000.00 | 5,709,429.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,780,500.00 | 5,796,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,934,400.00 | 4,077,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 436,800.00 | 428,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 350,400.00 | 319,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 303,900.00 | 111,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,755,000.00 | 859,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,144,700.00 | 3,774,926.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,041,400.00 | 1,323,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,003,300.00 | 1,873,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 490,950.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 276,000.00 | 1,007,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | 1,007,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 983,800.00 | 150,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 983,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 150,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 202,717,946.95 | 43,997,205.77 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,935,000.00 | 40,929,568.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 820,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,782,946.95 | 2,247,637.77 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,894,277.71 | 4,828,932.19 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,040,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,040,000.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 854,277.71 | 3,828,932.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 854,277.71 | 3,828,932.19 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **3,705,283.05** | **(2,177,205.77)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **3,705,283.05** | **(2,177,205.77)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,327,000.00 | 10,557,532.18 | 11,884,532.18 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,327,000.00** | **10,557,532.18** | **11,884,532.18** |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,327,000.00** | **10,557,532.18** | **11,884,532.18** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,327,000.00** | **10,557,532.18** | **11,884,532.18** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,327,000.00** | **10,557,532.18** | **11,884,532.18** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -2,177,205.77 | -2,177,205.77 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,327,000.00** | **8,380,326.41** | **9,707,326.41** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **265,432,700.00** | **101,611,600.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,000,000.00** | - |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 8,000,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 8,000,000.00 | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 8,000,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **257,432,700.00** | **101,611,600.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 201,000,000.00 | 41,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 201,000,000.00 | 41,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 56,432,700.00 | 60,611,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 56,432,700.00 | 60,611,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **265,432,700.00** | **101,611,600.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **265,432,700.00** | **101,611,600.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **260,538,422.29** | **96,782,667.81** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 41,930,192.29 | 44,234,741.81 |
| 210101 | Үндсэн цалин | 36,183,192.29 | 38,525,312.81 |
| 210104 | Урамшуулал | 5,747,000.00 | 5,709,429.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,780,500.00 | 5,796,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,934,400.00 | 4,077,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 436,800.00 | 428,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 350,400.00 | 319,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 303,900.00 | 111,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,755,000.00 | 859,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,274,700.00 | 3,774,926.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,171,400.00 | 1,323,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,003,300.00 | 1,873,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 100,000.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 490,950.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,092,230.00 | |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,092,230.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 276,000.00 | 1,007,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 276,000.00 | 1,007,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,184,800.00 | 150,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,184,800.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 150,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 201,000,000.00 | 41,820,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 201,000,000.00 | 41,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 820,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **4,894,277.71** | **4,828,932.19** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,040,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,040,000.00 | 1,000,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 854,277.71 | 3,828,932.19 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 854,277.71 | 3,828,932.19 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 60,611,600.00 | 56,782,667.81 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 60,611,600.00 | 56,782,667.81 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 59,611,600.00 | 55,782,667.81 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 44,330,300.00 | 44,234,741.81 |
| 210101 | Үндсэн цалин | 38,618,400.00 | 38,525,312.81 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 5,711,900.00 | 5,709,429.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,796,000.00 | 5,796,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,077,600.00 | 4,077,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 428,400.00 | 428,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 344,400.00 | 319,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 86,400.00 | 111,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 859,200.00 | 859,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,622,000.00 | 3,774,926.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,301,600.00 | 1,323,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,874,400.00 | 1,873,676.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 420,000.00 | 86,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,026,000.00 | 490,950.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,500,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 2,500,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,200,000.00 | 1,007,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200,000.00 | 1,007,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 330,000.00 | 150,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 150,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 833,300.00 | 820,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 833,300.00 | 820,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 12 | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **60,611,600.00** | **60,611,600.00** |
| 122 | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **60,611,600.00** | **60,611,600.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 60,611,600.00 | 60,611,600.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **41,000,000.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **41,000,000.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 41,000,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 41,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,000,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 41,000,000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 41,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 41,000,000.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж, бие даан шийдвэр гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

2117144066
ХТҮ4037 9030891

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 217.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 1.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 3.4 сая төгрөг болж 0.07 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.
Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.
Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 164.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь хэлмэгдэгсдийн үр хүүхдэд олгох нөхөн олговор 4 хүнээр буурсантай холбоотой байна.
Нийт зардал өмнөх оноос 158.4 сая төгрөгөөр буурсан нь нэг удаагийн тэтгэмжийн зардал буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 82.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 82.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 60.6 сая төгрөгийн төсөв баталснаас 58.1 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2.5 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 58.1 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 2.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 56.8 сая төгрөг буюу 92 хувийн гүйцэтгэлтэй буюу 3.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 41.0 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс хэлмэгдэгсдийн үр хүүхдэд олгох нөхөн олговорт 40.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Гурванзагал сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2021 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 200.0 сая төгрөгийн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй.